



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/17/-НА-СТА-ТШЗ

СОГТУУРАХ МАНСУУРАХ ДОНТОЙ ӨВЧТӨНГ АЛБАДАН ЭМЧЛЭХ,
АЛБАДАН ХӨДӨЛМӨР ХИЙЛГЭХ ГАЗРЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Шинжээч Т.Майцэцэг

Утас: 70273465 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СМДӨАЭАХХГ	Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.08.20 № 4/ЧО.
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 30 арга хэмжээтэй төлөвлөсөн ба гүйцэтгэлийн хэрэгжилт 97,0 хувийн биелэлттэй байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тайлант онд албан томилолтын зардлыг бүрэн хэмнэж бодит хэмнэлтийг бий болгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

019020047

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	114,339,993.25	60,051,269.91
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,000.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,000.00	-
3121	Төгрөг	30,000.00	-
31211	Төрийн сангийн харилцах	30,000.00	-
33	АВЛАГА	413,186.77	-
335	Бусад авлага	413,186.77	-
3351	Байгууллагаас авах авлага	413,186.77	-
35	БАРАА МАТЕРИАЛ	113,896,806.48	60,051,269.91
351	Түүхий эд материал	47,941,402.07	23,473,400.59
35110	Тусгай зориулалттай материал	19,280,648.16	15,595,643.16
35130	Эм боох материал	28,660,753.91	7,877,757.43
354	Хангамжийн материал	65,955,404.41	36,577,869.32
35410	Бичиг хэргийн материал	568,360.00	257,400.00
35420	Аж ахуйн материал	47,188,007.40	20,297,499.40
35440	Түлш, шатах тослох материал	4,893,081.96	4,357,953.30
35450	Барилгын засварын материал	2,341,000.00	440,000.00
35460	Хүнсний материал	10,964,955.05	11,225,016.62
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	928,989,604.26	794,537,223.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	928,989,604.26	794,537,223.54
392	Биет хөрөнгө	826,971,441.64	692,537,223.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	624,539,594.11	624,539,594.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(108,647,240.92)	(133,013,978.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,708,332.80	112,420,832.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(52,480,324.09)	(84,140,046.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	358,366,503.82	361,576,503.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(141,823,348.36)	(214,703,751.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,241,256.94	49,241,256.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,533,332.66)	(24,983,187.86)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	1,600,000.00	1,600,000.00
393	Биет бус хөрөнгө	102,018,162.62	102,000,000.00
39301	Програм хангамж	4,437,692.31	4,437,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,419,529.69)	(4,437,692.31)
39303	Бусад биет бус хөрөнгө	102,000,000.00	102,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,043,329,597.51	854,588,493.45
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,000.00	-
413	Өглөг	30,000.00	-
4136	Бусад өглөг	30,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	30,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,043,299,597.51	854,588,493.45
51	Засгийн газрын хувь оролцоо	1,043,299,597.51	854,588,493.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	512,937,694.90	512,937,694.90
51101	Өмч: - төрийн	512,937,694.90	512,937,694.90
512	Хуримтлагдсан үр дүн	242,882,035.49	54,170,931.43
51210	Өмнөх үеийн үр дүн	395,756,813.74	242,882,035.49
51220	Тайлант үеийн үр дүн	(152,874,778.25)	(188,711,104.06)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287,479,867.12	287,479,867.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,043,329,597.51	854,588,493.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,174,859,029.15	1,805,871,495.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	116,484,129.15	8,951,295.00
120	Нийтлэг татварын бус орлого	116,484,129.15	8,951,295.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	116,484,129.15	8,951,295.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	217,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	116,309,129.15	8,734,295.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,058,374,900.00	1,796,920,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,050,374,900.00	1,784,920,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,050,374,900.00	1,784,920,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,000,000.00	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	8,000,000.00	12,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,309,239,807.40	1,994,582,599.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,309,239,807.40	1,994,582,599.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,286,631,581.69	1,532,904,905.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	631,689,849.64	935,820,222.87
210101	Үндсэн цалин	377,201,750.58	557,847,092.82
210102	Нэмэгдэл	231,508,245.66	311,716,277.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт		14,892,900.00
210104	Урамшуулал	22,979,853.40	51,363,952.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	21,675,618.65	29,942,093.21
210201	Тэтгэврийн даатгал	796,492.32	-
210202	Тэтгэмжийн даатгал	93,704.98	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	74,963.99	-
210204	Ажилгүйдлийн даатгал	13,709.56	-
210205	Эрүүл мэндийн даатгал	20,696,747.80	29,942,093.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,113,909.23	150,687,827.56
210301	Гэрэл, цахилгаан	47,752,913.23	71,090,776.86
210302	Түлш, халаалт	51,952,896.00	77,597,050.70
210303	Цэвэр, бохир ус	2,408,100.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,134,394.46	20,472,135.96
210401	Бичиг хэрэг	831,733.50	2,554,960.00
210402	Тээвэр, шатахуун	11,101,822.04	11,787,777.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	928,000.00	900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,		93,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,168,438.92	5,135,498.00
210408	Бараа материал акталсны зардал	104,400.00	
2105	Нормативт зардал	265,378,557.71	223,198,184.91
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	129,502,461.81	76,864,996.48
210502	Хоол, хүнс	135,876,095.90	118,783,938.43
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		27,549,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,440,900.00	20,195,460.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,900.00	241,900.00
210604	Урсгал засвар	49,199,000.00	19,953,560.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,278,920.00	7,165,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,266,720.00	1,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	658,900.00	658,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,300.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,300.00	25,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	771,700.00	4,771,700.00
210807	Газрын төлбөр	310,000.00	310,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,919,432.00	145,423,080.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,211,996.00	3,593,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	454,730.00	455,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,252,706.00	141,374,880.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,608,225.71	461,677,693.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,518,182.00	461,559,976.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		460,817,376.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,518,182.00	742,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,090,043.71	117,717.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,090,043.71	117,717.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(134,380,778.25)	(188,711,104.06)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,494,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	18,494,000.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(18,494,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(152,874,778.25)	(188,711,104.06)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,058,549,900.00	1,797,003,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,000.00	83,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	175,000.00	83,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,000.00	83,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	83,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,058,374,900.00	1,796,920,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,050,374,900.00	1,784,920,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,050,374,900.00	1,784,920,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,000,000.00	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	8,000,000.00	12,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,012,719,800.00	1,793,823,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,012,719,800.00	1,793,823,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	990,111,574.29	1,332,145,506.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	631,689,849.64	935,820,222.87
210101	Үндсэн цалин	377,201,750.58	557,847,092.82
210102	Нэмэгдэл	231,508,245.66	311,716,277.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,892,900.00
210104	Урамшуулал	22,979,853.40	51,363,952.65

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	21,675,618.65	29,942,093.21
210201	Тэтгэврийн даатгал	796,492.32	-
210202	Тэтгэмжийн даатгал	93,704.98	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	74,963.99	-
210204	Ажилгүйдлийн даатгал	13,709.56	-
210205	Эрүүл мэндийн даатгал	20,696,747.80	29,942,093.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,115,400.00	150,533,690.09
210301	Гэрэл, цахилгаан	48,166,100.00	70,677,590.09
210302	Түлш, халаалт	55,541,200.00	77,856,100.00
210303	Цэвэр, бохир ус	2,408,100.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,535,100.00	16,570,500.00
210401	Бичиг хэрэг	610,600.00	2,083,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,896,000.00	10,993,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	928,000.00	900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	93,900.00	93,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,006,600.00	2,500,000.00
2105	Нормативт зардал	150,650,200.00	173,096,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,289,200.00	55,292,000.00
210502	Хоол, хүнс	86,361,000.00	117,804,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,241,900.00	15,031,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,790,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,900.00	241,900.00
210604	Урсгал засвар	50,000,000.00	13,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,211,500.00	7,165,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,199,300.00	1,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	658,900.00	658,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,300.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,300.00	25,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	771,700.00	4,771,700.00
210807	Газрын төлбөр	310,000.00	310,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,992,006.00	3,985,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,536,806.00	3,530,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	455,200.00	455,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,608,225.71	461,677,693.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,518,182.00	461,559,976.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	460,817,376.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,518,182.00	742,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,090,043.71	117,717.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,090,043.71	117,717.83
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	45,830,100.00	3,180,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН	45,830,100.00	3,210,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,830,100.00	3,210,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,830,100.00	3,210,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан	45,830,100.00	3,210,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(45,830,100.00)	(3,210,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(30,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	30,000.00	30,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	30,000.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	395,756,813.74		1,196,174,375.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	0.00	0.00	0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	395,756,813.74	0.00	1,196,174,375.76
C07	Тайлант үеийн үр дүн			-152,874,778.25		-152,874,778.25
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	242,882,035.49	0.00	1,043,299,597.51
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	242,882,035.49	0.00	1,043,299,597.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	0.00	0.00	0.00		0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	242,882,035.49	0.00	1,043,299,597.51
D08	Тайлант үеийн үр дүн			-188,711,104.06		-188,711,104.06
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	512,937,694.90	287,479,867.12	54,170,931.43	0.00	854,588,493.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,785,074,200.00	1,784,885,482.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,785,074,200.00	1,784,885,482.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,323,514,200.00	1,323,325,506.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	935,825,400.00	935,820,222.87
210101	Үндсэн цалин	577,808,200.00	557,847,092.82
210102	Нэмэгдэл	310,155,200.00	311,716,277.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,705,000.00	14,892,900.00
210104	Урамшуулал	32,157,000.00	51,363,952.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,967,400.00	29,942,093.21
210205	Эрүүл мэндийн даатгал	29,967,400.00	29,942,093.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150,620,900.00	150,533,690.09
210301	Гэрэл, цахилгаан	70,764,800.00	70,677,590.09
210302	Түлш, халаалт	77,856,100.00	77,856,100.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,641,500.00	14,570,500.00
210401	Бичиг хэрэг	1,154,000.00	1,083,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,993,600.00	10,993,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгах	93,900.00	93,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,500,000.00
2105	Нормативт зардал	171,096,000.00	171,096,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	55,292,000.00	55,292,000.00
210502	Хоол, хүнс	115,804,000.00	115,804,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,241,900.00	10,241,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,900.00	241,900.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	7,165,900.00	7,165,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	1,200,000.00	1,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	658,900.00	658,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,300.00	25,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,771,700.00	4,771,700.00
210807	Газрын төлбөр	310,000.00	310,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,955,200.00	3,955,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	455,200.00	455,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	461,560,000.00	461,559,976.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	461,560,000.00	461,559,976.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	460,817,400.00	460,817,376.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	742,600.00	742,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,785,074,200.00	1,784,885,482.17
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,784,920,200.00	1,784,802,482.17
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,784,920,200.00	1,784,802,482.17
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	154,000.00	83,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	154,000.00	83,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,000,000.00	12,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,000,000.00	12,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,000,000.00	12,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,000,000.00
210401	Бичиг хэрэг	-	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,000,000.00
2105	Нормативт зардал	-	2,000,000.00
210502	Хоол, хүнс	-	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	8,000,000.00
210604	Урсгал засвар	-	8,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,000,000.00	12,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,000,000.00	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	12,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь архинд донтох эмгэгтэй этгээдийг албадан эмчлэх чиг үүрэг бүхий Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэдэг Хууль зүйн яамны харьяа төрийн байгууллага юм.

Тус газар нь захиргаа, санхүү аж ахуйн алба, эмнэлгийн алба, харуул хамгаалалтын алба гэсэн 3 албатай, 49 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын хэмжээнд 2023 оныг "Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, аюулгүй байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, алба хаагчийн хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ШШГЕГ-ын даргатай 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан ба гүйцэтгэлийн хэрэгжилт 97,0 хувиар биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь үйл ажиллагаандаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

"Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн шинэ барилга бариулах ажлыг эхлүүлэх" арга хэмжээ нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын шийдвэрээр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт баригдахаар шийдвэрлэгдэж, барилгын төслийн ажил хийгдэж байгаа нь тус байгууллага байршил өөрчлөгдөх магадлалтай гэж үзэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох баримт бичигт өөрчлөлт оруулан мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/13 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналт, шалгалт явуулах комисс байгуулж шалгалт явуулах хуваарь баталсан байна. Төв аймгийн Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын дотоод хяналтын ажлын хэсэг нь 2023 онд 11 ажил төлөвлөснөөс эмнэлгийн, сэтгэл зүйн, харуул хамгаалалт, санхүүгийн, дотоод ажлын албаны чиглэлээр шалгаж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар тухай бүр хугацаатай үүрэг өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь ШШГЕГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 188,741.1 мянган төгрөгөөр буюу 18,1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30.0	0.0	(30.0)
Авлага	413.2	0.0	(413.2)
Бараа материал	113,896.8	60,051.3	(53,845.5)
Үндсэн хөрөнгө	928,989.6	794,537.2	(134,452.4)
Нийт хөрөнгө	1,043,329.6	854,588.5	(188,741.1)
Өр төлбөр	30.0	0.0	(30.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1043,299.6	854,588.5	(188,711.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,043,329.6	854,588.5	(188,741.1)

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын үлдэгдэл 60,051.3 мянган төгрөг болж 53,845.5 мянган төгрөгөөр буурсан нь Ар гүнт дэх сайн дурын эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн эмчлүүлэгчийн эм, хоол хүнсний материал зарцуулагдаж, түүхий эд материал 24,468.0 мянган төгрөгөөр, хангамжийн материал 29,377.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 794,537.2 мянган төгрөг болж 134,452.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 3,210.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй орлогоор 3,712.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн бүртгэсэн болон тайлант хугацаанд 141,374.9 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардал тооцоноос шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,908,931.90 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого байхгүй, нийт зарлагыг 2,908,931.90 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

ШШГЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны “2023 оны төсөв батлах тухай” А/286 дугаар тушаалаар тус байгууллагын төсвийн төслийн саналаас 1,124,011.70 мянган төгрөгөөр зардлыг бууруулж 1,784,920.20 мянган төгрөгөөр баталсан байна.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын төсвийн төсөлд тусгасан зардлаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 156,765.20 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 63,115.20 мянган төгрөг, эм, эмнэлгийн хэрэгсэл 976,120.70 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 731,170.50 мянган төгрөгийг тус тус бууруулсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд батлагдсан төсөв хүрэлцэхгүйгээс ШШГЕГ-ын санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газарт хүсэлт явуулж, батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2023 оны батлагдсан төсвийг 895,647.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,784,920.2 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,784,920.2 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,784,920.2 мянган төгрөгийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого 83.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,784,885.5 мянган төгрөг буюу 99.99 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 117.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,784,920.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 100 хувь санхүүжүүлж, үйл ажиллагааны орлогоор 83.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 117.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70705/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,784,458.7	1,784,341.0	117.7	99.99%
2	70705/80102 Туслах үйл ажиллагааны орлого	0.0	83.0	83.0	100%
3	70705/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	461.5	461.5	0	100%
	ДҮН	1,784,920.2	1,784,885.5	200.7	99.99%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь тайлант онд ШШГЕГ-аас шилдэг салбар нэгжээр шалгарч тэргүүн байрны шагнал 10,000.0 мянган төгрөг, мөн 5 төрөлт спортын тэмцээнд багийн амжилтаар 2 дугаар байр эзэлж 2,000.0 мянган төгрөг, нийт 12,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт шүүхийн шийдвэр гүйцэтгэл 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөр байхгүй.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70705 шүүхийн шийдвэр гүйцэтгэл	1 жил	Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдана.	99.99%	1,784,920.2	1,784,885.5

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 146,576.2 мянган төгрөгийн эм боох материал, түлш халаалт, хоол хүнсийг тендер шалгаруулалтын онцгой журмаар, багаж техник хэрэгсэл, шатахуун, цахилгаан дулаан, цэвэр бохир усны үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргаар худалдан авахаар төлөвлөсөн байна. Худалдан авах ажиллагааны журмын дагуу тендер сонгон шалгаруулалт явуулж, гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд цахим дэлгүүрт байгаа 18 нэр төрлийн 134 ш 2,005.7 мянган төгрөгийн эм тариаг худалдан авсан. Цахим дэлгүүрт бараа материалын сонголт нэр төрөл хангалтгүй байдаг тул худалдан авалт хийх боломж бүрдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг гэрээт шинжээч Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/27 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1,994,582.6 мянган төгрөгийн нийт зарлагын дүнгээс 1,5 хувиар буюу 29,918.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 22,439.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ШШГЕГ-ын даргын “Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг тооцон, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлж, төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн тус газар нь албан томилолтын зардлыг батлаагүйгээс тус зардал бүрэн хэмнэгдэж, 1,260.0 мянган төгрөгийн бодит хэмнэлтийг бий болгосон байна. Мөн тус байгууллагад 2023 онд ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт эмчлүүлэхэд, мөн өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрахад ирж, очих замын зардлыг олгоогүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад тайлант хугацаанд шилэн дансанд 159 мэдээлэл байршуулахаас хугацаандаа бүрэн байршуулсан. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17 орлогын, 14 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг хугацаандаа бүрэн байршуулж, улирал бүр хяналт шалгалт хийсэн тайланг ШШГЕГ-т хүргүүлж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын 2023 оны эхний 9 сарын байдлаарх санхүүгийн тайлан баримтад завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр ирүүлсэн. Аудитаар хэрэгжилтийг хянаж, бүрэн хэрэгжүүлсэн гэж үнэлсэн тул аудитын тайланд тусгах шаардлагагүй гэж үзлээ. Үүнд:

1. Байгууллагын данс бүртгэлд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн замын хураамж, торгууль, авто тээврийн хэрэгслийн албан татварын дутуу төлөлт нийт 1,413.7 мянган төгрөгийг төсөвт төлж барагдуулсан.

2. Хүнсний материалын тендер сонгон шалгаруулалтаар гэрээнд тусгагдаагүй материал нийлүүлэх, үнийн огцом өсөлт гарсан тохиолдолд өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлдэг болсон.

3. Хууль зүй Дотоод хэргийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/75 дугаар тушаалаар төсвийн мэдээллийг ил тод болгох хүрээнд Даталанд технологи ХХК-тай гэрээ байгуулан Төсвийн нэгдсэн системийг нийлүүлэх, ашиглах, хөгжүүлэхтэй холбогдсон үйлчилгээний хөлсөнд шилжүүлж, зардалд бичсэн зөрчлийг арилган орлогоор бүртгэх зөвлөмж өгөгдсөнийг ҮАГ-тай ярилцаж зөвлөснөөр зардалд бичилт хийхийг зөвшөөрсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 03-ны өдөр 01/576 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	10,212.0	1	10,212.0	100
Зөвлөмж					
Нийт дүн	1	10,212.0	1	10,212.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 9,614.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 4 зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Орлогын талаар

Цахим тендерийн бичиг баримтын 134.0 мянган төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээний тайланд бууруулан тайлагнасан зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах" гэсэн заалтыг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Туслах үйл ажиллагааны орлогыг үнэн зөв тайлагнаж байх

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацаанд ТӨБЗГ-ын 2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А-2/33 дугаар тогтоолын дагуу Хэрэмт цамхаг УТҮГ-аас Киа Сирота маркын 3,712.5 мянган төгрөгийн авто машиныг балансаас балансад шилжүүлэн авч данс бүртгэлд тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Төсвийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "тасалбар болголт", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-ын шийдвэр гарсан тохиолдолд хөрөнгийг шилжүүлж байх

3. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Барилга байгууламж дансанд бүртгэлтэй 5,768.4 мянган төгрөгийн 2 орон сууц нь Багахангай дүүрэгт байршдаг, эзэмшил нь иргэний нэр дээр байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2/ төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Барилга байгууламж дансанд бүртгэлтэй 2 орон сууцны эзэмшлийн асуудлыг холбогдох газраар шийдвэрлүүлэн зөрчлийг арилгах

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэж заасны дагуу тус байгууллагын Лексус 470 машин Тахарын албанаас 2021 онд балансаас балансад шилжиж ирэхдээ байгууллагын нэр дээр албан ёсоор шилжүүлээгүйгээс шалтгаалан бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Лексус 470 машиныг зөрчлийг арилгаж, тод дэвсгэр бүхий улсын дугаар авах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газарт батлагдсан төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 25-ны дотор, хэрэгжилт биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлого бууруулан тайлагнасан	1	134.0					1	134.0				
2024,01,09-ны шийдвэр бүхий авто машин бүртгэсэн	1	3,712.5					1	3,712.5				
Орон сууц эзэмших эрх иргэний нэр дээр	1	5,768.4					1	5,768.4				
Улсын тод дугаар аваагүй	1	0					1	0				
Дүн	4	9,614.9					4	9,614.9				